



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ сумын ЗДТГ-ын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: БУА-2021/71/СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Булган аймаг

2021 он

Тэргүүлэх аудитор: Д.Анхбаяр

Утас: 70342580 Цахим хаяг: Ankhubayard@audit.gov.mn

Аудитын менежер: Ж.Энхцоодол

Утас: 70342716 Цахим хаяг: Enkhtsoodolj@audit.gov.mn

Ахлах аудитор: П.Содном

Утас: 70342495 Цахим хаяг: Sodnomp@audit.gov.mn

Аудитор: А.Сувдаа

Утас: 70342495 Цахим хаяг: Suvdaaa@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт

АДБОУС Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт

АОУС Аудитын Олон Улсын Стандарт

ЗДТГ Засаг даргын тамгын газар

НББ Нягтлан бодох бүртгэл

НӨАТ Нэмэн өртгийн албан татвар

Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	9
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	11
3.Аудитын тайлан.....	11
3.1. Ерөнхий зүйл.....	12
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй.....	12
3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт	13
3.4. Материаллаг байдал	13
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	13
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт	14
3.7. Шилэн дансны мэдээлэл.....	15
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	15
3.9. Аудитын илрүүлэлт.....	15
Залруулсан алдаа.....	15
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил	15
Аудитын зөвлөмж.....	16
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд	16
4. Менежментийн захидал	16
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	Error! Bookmark not defined.



**БУЛГАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

63082 Булган аймаг, Булган сум, Жаргалант баг,
Утас: 7034-2580, Факс: 7034-2580

2021.02.25 № 97
танай _____ -ны № _____ т

СЭЛЭНГЭ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА
Ц.УУГАНБАЯР ТАНАА

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Булган аймгийн Сэлэнгэ сумын Засаг даргын тамгын газрын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Булган аймгийн Сэлэнгэ сумын Засаг даргын тамгын газрын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Бусад мэдээлэл нь санхүүгийн ба санхүүгийн бус мэдээллийг агуулсан байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

006020163

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Д.АНХБАЯР

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

СТ-1А

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	159,538,819.00	58,275,739.00
35	БАРАА МАТЕРИАЛ	159,538,819.00	58,275,739.00
354	Хангамжийн материал	148,845,219.00	49,383,739.00
35420	Аж ахуйн материал	39,657,319.00	38,499,239.00
35470	Бусад хангамжийн материал	109,187,900.00	10,884,500.00
35600	Мал амьтад	10,693,600.00	8,892,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	706,078,283.95	989,767,795.27
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	706,078,283.95	989,767,795.27
392	Биет хөрөнгө	706,078,283.95	975,983,795.27
39201	Барилга, байгууламж, орон сууц	388,343,728.14	388,343,728.14
39202	Хуримтлагдсан элэгдэл	(6,433,936.28)	(9,409,904.42)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	445,807,740.00	533,907,740.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(304,625,025.04)	(295,161,211.58)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	160,087,714.95	229,480,821.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(133,929,740.22)	(103,271,563.18)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	27,593,987.30	18,344,149.10
39208	Хуримтлагдсан элэгдэл	(23,842,058.16)	(14,326,764.83)
39214	Бусад үндсэн хөрөнгө	346,076,513.00	419,477,080.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(193,000,639.74)	(191,400,278.96)
393	Биет бус хөрөнгө	-	13,784,000.00
39301	Програм хангамж	300,000.00	300,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(300,000.00)	(300,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	-	13,784,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	865,617,102.95	1,048,043,534.27
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	865,617,102.95	1,048,043,534.27
51	Засгийн газрын хувь оролцоо	865,617,102.95	1,048,043,534.27
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	444,230,431.00	458,014,431.00
512	Хуримтлагдсан үр дүн	15,821,113.45	184,463,544.77
51210	Өмнөх үеийн үр дүн	15,821,113.45	15,821,113.45
51220	Тайлант үеийн үр дүн	-	168,642,431.32
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	405,565,558.50	405,565,558.50
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	865,617,102.95	1,048,043,534.27

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

СТ-2А

САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	616,525,538.00	1,029,520,995.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	9,232,490.00	94,688,547.00
120	Нийтлэг татварын бус орлого	9,232,490.00	94,688,547.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	6,044,990.00	6,475,580.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	315,000.00	311,600.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	5,729,990.00	6,163,980.00
120009	Бусад орлого	3,187,500.00	-
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого -Үндсэн хөрөнгө		85,900,567.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого -Бараа материал		2,312,400.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	607,293,048.00	934,832,448.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	240,044,280.00	320,609,318.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	5,000,000.00	
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	83,403,900.00	43,012,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,640,380.00	4,114,286.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	150,000,000.00	273,483,032.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	367,248,768.00	614,223,130.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	367,248,768.00	614,223,130.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	687,222,976.45	758,010,963.68
21	УРСГАЛ ЗАРДАЛ	687,222,976.45	758,010,963.68
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	687,222,976.45	735,774,863.68
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	239,749,115.00	266,432,988.00
210101	Үндсэн цалин	154,794,615.00	174,262,026.00
210102	Нэмэгдэл	40,879,800.00	48,847,262.00
210104	Урамшуулал	2,432,000.00	972,000.00
210105	Гэрээт ажлын хөлс	41,642,700.00	42,351,700.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	29,561,371.00	31,489,667.00
210201	Тэтгэврийн даатгал	20,176,200.00	20,903,502.71
210202	Тэтгэмжийн даатгал	2,362,435.00	2,614,364.29
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,890,564.00	2,125,800.00
210204	Ажилгүйдлийн даатгал	472,666.00	531,500.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,659,506.00	5,314,500.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	21,416,300.00	20,796,030.00
210301	Гэрэл, цахилгаан	3,936,300.00	6,177,950.00
210302	Түлш, халаалт	17,480,000.00	14,618,080.00
2104	Хангамж, бараа материалын зардал	22,098,350.00	26,107,170.00
210401	Бичиг хэрэг	3,074,000.00	2,555,200.00
210402	Тээвэр, шатахуун	17,222,750.00	20,588,290.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,801,600.00	1,805,600.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	-	1,158,080.00
2105	Нормативт зардал	1,000,000.00	204,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,000,000.00	204,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,315,680.00	7,147,800.00
210604	Урсгал засвар	7,315,680.00	7,147,800.00
2107	Томилолт, зочны зардал	10,361,500.00	2,213,100.00
210702	Дотоод албан томилолт	10,361,500.00	2,213,100.00

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	15,567,602.00	38,535,599.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	14,353,820.00	37,105,699.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	108,000.00	324,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	418,770.00	418,800.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	402,800.00	402,800.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	215,212.00	215,300.00
210807	Газрын төлбөр	69,000.00	69,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	340,153,058.45	342,848,509.68
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	243,028,970.00	302,721,674.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,498,080.00	200,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	92,626,008.45	39,926,835.68
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	22,236,100.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	22,236,100.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	21,041,100.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	1,195,000.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(70,697,438.45)	271,510,031.32
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	15,580,300.00	102,571,900.00
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	2,466,300.00	55,000.00
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	13,114,000.00	102,516,900.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(15,580,300.00)	(102,571,900.00)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(86,277,738.45)	168,938,131.32

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

СТ-2А

МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	607,608,048.00	935,144,048.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	315,000.00	311,600.00
120	Нийтлэг татварын бус орлого	315,000.00	311,600.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	315,000.00	311,600.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	315,000.00	311,600.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	607,293,048.00	934,832,448.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	240,044,280.00	320,609,318.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	5,000,000.00	
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	83,403,900.00	43,012,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,640,380.00	4,114,286.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	150,000,000.00	273,483,032.00

1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	367,248,768.00	614,223,130.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	367,248,768.00	614,223,130.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	597,608,048.00	717,046,048.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	597,608,048.00	717,046,048.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	597,608,048.00	695,284,948.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	239,749,115.00	266,697,700.00
210101	Үндсэн цалин	154,794,615.00	166,766,200.00
210102	Нэмэгдэл	40,879,800.00	57,238,300.00
210104	Урамшуулал	2,432,000.00	972,000.00
210105	Гэрээт ажлын хөлс	41,642,700.00	41,721,200.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	29,561,371.00	33,215,700.00
210201	Тэтгэврийн даатгал	20,176,200.00	22,586,700.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,362,435.00	2,657,200.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,890,564.00	2,125,800.00
210204	Ажилгүйдлийн даатгал	472,666.00	531,500.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,659,506.00	5,314,500.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	21,416,300.00	20,796,030.00
210301	Гэрэл, цахилгаан	3,936,300.00	6,177,950.00
210302	Түлш, халаалт	17,480,000.00	14,618,080.00
2104	Хангамж, бараа материалын зардал	21,445,380.00	21,947,400.00
210401	Бичиг хэрэг	3,024,800.00	2,555,200.00
210402	Тээвэр, шатахуун	16,614,980.00	17,586,600.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,805,600.00	1,805,600.00
2105	Нормативт зардал	1,000,000.00	600,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,000,000.00	600,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,361,100.00	7,147,800.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,450,000.00	-
210604	Урсгал засвар	5,911,100.00	7,147,800.00
2107	Томилолт, зочны зардал	10,348,800.00	2,213,100.00
210702	Дотоод албан томилолт	10,348,800.00	2,213,100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	36,105,982.00	37,957,546.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	34,892,200.00	36,527,646.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	108,000.00	324,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	418,770.00	418,800.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	402,800.00	402,800.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	215,212.00	215,300.00
210807	Газрын төлбөр	69,000.00	69,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	230,620,000.00	304,709,672.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	226,000,000.00	304,509,672.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,620,000.00	200,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	21,761,100.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	21,761,100.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	21,041,100.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	720,000.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	10,000,000.00	218,098,000.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	10,000,000.00	218,098,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	10,000,000.00	218,098,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	10,000,000.00	218,098,000.00
222001	Тоног төхөөрөмж	10,000,000.00	190,098,000.00
223001	Бусад хөрөнгө	-	28,000,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(10,000,000.00)	(218,098,000.00)
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	=	=

8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

СТ-4А

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	444,230,431.00	405,565,558.50	15,821,113.45		865,617,102.95
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-		-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	444,230,431.00	405,565,558.50	15,821,113.45	-	865,617,102.95
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-		-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-		-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-		-
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	-		-
C08	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	444,230,431.00	405,565,558.50	15,821,113.45	-	865,617,102.95
D01	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	444,230,431.00	405,565,558.50	15,821,113.45	-	865,617,102.95
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-		-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	444,230,431.00	405,565,558.50	15,821,113.45	-	865,617,102.95
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-		-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	13,784,000.00	-	-		13,784,000.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-		-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-		-
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	168,642,431.32		168,642,431.32
D09	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	458,014,431.00	405,565,558.50	184,463,544.77	-	1,048,043,534.27

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Өмнөх оны		Тайлант он	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	367847100.00	367537168.00	614396400.00	614534730.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	367847100.00	367537168.00	430298400.00	424766930.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	367847100.00	367537168.00	409257300.00	403725830.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	237371300.00	237317115.00	265725700.00	265725700.00

Сэлэнгэ сумын ЗДТГ-ын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210101	Үндсэн цалин	154848800.00	154794615.00	166766200.00	166766200.00
210102	Нэмэгдэл	40879800.00	40879800.00	57238300.00	57238300.00
210105	Гэрээт ажлын хөлс	41642700.00	41642700.00	41721200.00	41721200.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	29671400.00	29561371.00	33215700.00	33215700.00
210201	Тэтгэврийн даатгал	20176400.00	20176200.00	22586700.00	22586700.00
210202	Тэтгэмжийн даатгал	2373800.00	2362435.00	2657200.00	2657200.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1899000.00	1890564.00	2125800.00	2125800.00
210204	Ажилгүйдлийн даатгал	474800.00	472666.00	531500.00	531500.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4747400.00	4659506.00	5314500.00	5314500.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	21416300.00	21416300.00	20796300.00	20796030.00
210301	Гэрэл, цахилгаан	3936300.00	3936300.00	2696300.00	6177950.00
210302	Түлш, халаалт	17480000.00	17480000.00	18100000.00	14618080.00
2104	Хангамж, бараа материалын зардал	19960100.00	19960100.00	19367400.00	19697600.00
210401	Бичиг хэрэг	3024800.00	3024800.00	2555200.00	2885400.00
210402	Тээвэр, шатахуун	15129700.00	15129700.00	15006600.00	15006600.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,805,600.00	1,805,600.00	1,805,600.00	1,805,600.00
2105	Нормативт зардал	1,000,000.00	1,000,000.00	600,000.00	600,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,000,000.00	1,000,000.00	600,000.00	600,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,361,100.00	7,361,100.00	13,147,800.00	7,147,800.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,450,000.00	1,450,000.00	6,000,000.00	-
210604	Урсгал засвар	5,911,100.00	5,911,100.00	7,147,800.00	7,147,800.00
2107	Томилот, зочны зардал	9,938,100.00	9,793,700.00	2,074,500.00	2,213,100.00
210702	Дотоод албан томилолт	9,938,100.00	9,793,700.00	2,074,500.00	2,213,100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	11,008,800.00	11,007,482.00	24,129,900.00	24,129,900.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	9,793,700.00	9,793,700.00	22,700,000.00	22,700,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	108,000.00	108,000.00	324,000.00	324,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	420,000.00	418,770.00	418,800.00	418,800.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	402,800.00	402,800.00	402,800.00	402,800.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	215,300.00	215,212.00	215,300.00	215,300.00
210807	Газрын төлбөр	69,000.00	69,000.00	69,000.00	69,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	30,120,000.00	30,120,000.00	30,200,000.00	30,200,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	25,500,000.00	25,500,000.00	30,000,000.00	30,000,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,620,000.00	4,620,000.00	200,000.00	200,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	-	21,041,100.00	21,041,100.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	-	21,041,100.00	21,041,100.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	-	21,041,100.00	21,041,100.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	-	184,098,000.00	189,767,800.00
2200	Дотоод эх үүсвэрээр	-	-	184,098,000.00	189,767,800.00
222001	Тоног төхөөрөмж	-	-	184,098,000.00	95,717,900.00
223001	Бусад хөрөнгө	-	-	-	94,049,900.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	367,847,100.00	367,563,768.00	614,396,400.00	614,534,730.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	362,547,100.00	367,248,768.00	608,096,400.00	614,223,130.00
132001	Орон нутгийн төсвөөс	362,547,100.00	367,248,768.00	608,096,400.00	614,223,130.00

120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	5,300,000.00	315,000.00	6,300,000.00	311,600.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	300,000.00	315,000.00	300,000.00	311,600.00
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	5,000,000.00		6,000,000.00	

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

НТ-2

НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	320,609,318.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	292,609,318.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	291,889,318.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	-	972,000.00
210104	Урамшуулал	-	972,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	-	2,580,000.00
210402	Тээвэр, шатахуун	-	2,580,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	13,827,646.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	13,827,646.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	274,509,672.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	274,509,672.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	720,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	720,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	720,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	28,000,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	-	28,000,000.00
223001	Бусад хөрөнгө	-	28,000,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	320,609,318.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	320,609,318.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	43,012,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	4,114,286.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		273,483,032.00

3.Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Сэлэнгэ сумын ЗДТГ-ын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг Сэлэнгэ сумын ЗДТГ-ын дарга Ц.Ууганбаяр танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангах, нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн нийцэл, батлагдсан төсвийг зориулалтын дагуу үр ашигтай зарцуулах талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 02 дугаар сарын 3-аас 2021 оны 02 дугаар сарын 25-ны Булган аймаг дахь Төрийн аудитын газрын Тэргүүлэх аудитор Д.Анхбаяр хоёр дахь шатны, аудитын менежер Ж.Энхцоодол, ахлах аудитор П.Содном нар анхан шатны хяналтыг тус тус хэрэгжүүлэн, аудитор А.Сувдаа хариуцан гүйцэтгэв.

Сэлэнгэ сумын ЗДТГ-ын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Булган аймаг дахь төрийн аудитын газар-т 2021 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 3/10 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг, тооллого явуулах тухай Засгийн газрын 2020 оны 9 дүгээр тогтоол
- Улсын үзлэгийн мөрөөр авах зарим арга хэмжээний тухай Засгийн газрын 2020 оны А/106 дугаар
- Бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан эдийн засгийг дэмжих чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай Засгийн газрын 114 дүгээр тогтоол
- Төрийн албаны цалингийн нэгдсэн систем нэвтрүүлэх тухай Засгийн газрын 163 дугаар тогтоол,
- Төсвийн ерөнхийлөн захирагч нарт зохицуулалтын эрх олгох тухай Засгийн газрын 187 дугаар тогтоол
- Мал, тэжээвэр амьтдын 2020 оны тооллогын товыг өөрчлөх тухай Засгийн газрын 208 дугаар тогтоол
- Засгийн газрын 217, 218 дугаар тогтоол
- Засаг даргын А/01 дугаар захирамж “ЗДТГ-ын бүтэц орон тоог шинэчлэн батлах тухай”
- Засаг даргын А/02 дугаар захирамж “Тамгын газрын дарга, Багийн засаг дарга, байгууллагын дарга, эрхлэгч нарын цалинг шинэчлэн тогтоох тухай”
- Засаг даргын А/50 “Хөдөлмөрийн дотоод журмыг шинэчлэн батлах тухай”

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Сэлэнгэ сумын ЗДТГ санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцээсэн байна.

Тайлант хугацаанд тус байгууллагад Санхүү хяналт аудитын газар санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгээгүй байна.

3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “17217.6 мянган төгрөг” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны жилийн тайлангийн нийт зардлын 860878.6 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 17217.6 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд өөрчлөх шаардлагагүй гэж үзлээ.

3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Сэлэнгэ сумын ЗДТГ-ын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 182426.4 мянган төгрөгөөр буюу 21.1 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0	0	0
Авлага	0	0	0
Урьдчилгаа	0	0	0
Бараа материал	159538.8	58275.7	(101263.1)
Үндсэн хөрөнгө	706078.3	989767.8	283689.5
Нийт хөрөнгө	865617.1	1048043.5	182426.4
Өр төлбөр	0	0	0
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	865617.1	1048043.5	182426.4
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	865617.1	1048043.5	182426.4

Мөнгөн хөрөнгө болон авлага дансны үлдэгдэлгүй байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 58275.7 мянган төгрөг болж 101263.1 мянган төгрөгөөр буурсан нь бусад хангамжийн материалаас 99334.9 мянган төгрөгийн хөрөнгийг Хөдөө аж ахуйн газарт шилжүүлснээс шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 989767.8 мянган төгрөг болж 283689.5 мянган төгрөгөөр өссөн нь хөрөнгө бэлтгэснээс шалтгаалжээ. Үндсэн хөрөнгийн данс нь хөрөнгө

оруулалт, урсгал төсвийн худалдан авалтаар 218098.0 мянган төгрөг, хандиваар болон үнэ төлбөргүй шилжиж ирсэн мянган төгрөгийн 85900.6 мянган төгрөгийн хөрөнгөөр нэмэгдсэн байна.

Үндсэн хөрөнгө үнэ төлбөргүй шилжүүлсэн 5000.0, дахин үнэлсэн 38427.4, акталсан 44761.2 мянган төгрөгийн хөрөнгөөр хасагдсан байна.

Биет бус хөрөнгөнд өөрчлөлт ороогүй байна.

Өр төлбөр дансны үлдэгдэлгүй байна

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1048043.5 мянган төгрөг болж 182426.4 мянган төгрөгөөр өссөн нь хөрөнгө бэлтгэсэн, дахин үдэлсэн хөрөнгийн орлогоор хүлээн зөвшөөрсөн, үнэ төлбөргүй хөрөнгө шилжүүлэн авснаас шалтгаалжээ.

2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 412995.5 мянган төгрөгөөр буюу 40.1 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нэмэлт санхүүжилтийн орлого, үнэ төлбөргүй хүлээн авсан орлого, урсгал үйл ажиллагааны орлого байна.

Нийт зардал өмнөх оноос 70787.9 мянган төгрөгөөр буюу 9.3 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан цалин хөлс болон нэмэгдэл урамшил, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж, тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмжийн зардлууд байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү хаасан нягтлан бодох бүртгэлийн залруулга байхгүй байна.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 530005.7 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 530005.7 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 127097.8 мянган төгрөгөөр бууруулж 402907.9 мянган төгрөгөөр баталсныг ИТХ-ын 2020 оны 09/01 тоот тогтоолоор 430298.4 мянган төгрөг тодотгон баталсан байна.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 8 арга хэмжээг санхүүжүүлэхээр 614396.4 мянган төгрөгийн төсөв баталснаас 608096.4 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс 300.0 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоор санхүүжүүлэхээр, 6000.0 мянган төгрөг урьд оны үлдэгдлээс санхүүжихээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 614223.1 мянган төгрөгийн санхүүжилт авч, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлого 311.6 мянган төгрөг, нийт 614534.7 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 424766.9 мянган төгрөгийг, 189767.8 мянган төгрөгийг хөрөнгийн зардалд зарцуулжээ.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 614534,7 мянган төгрөг буюу 99.8 хувьтай байгаа нь хангамж бараа материалын 330.2, томилолт зочны зардал 138.6, хөрөнгийн зардал

5669.8 мянган төгрөгөөр тус тус илүү, эд хогшил урсгал засварын зардал 6000.0 мянган төгрөгөөр дутуу зарцуулсантай холбоотой байна.

Нийт төсвийн зардлын гүйцэтгэлийг дутуу зарцуулсан нь 1 хөтөлбөрийн 1 арга хэмжээ 138.6 дутуу зарцуулагдсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 3.6-д харуулав.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Засаг даргын нөөц хөрөнгөнөөс 43012.0, дээд шатны төсвийн захирагчаас 4114.3, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 273483.0 мянга, нийт 320609.3 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс урамшуулалд 972.0, тээвэр шатахуунд 2580.0, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжид 13827.6, бараа үйлчилгээний бусад зардалд 274509.7, хөрөнгийн зардалд 28000.0 мянган төгрөгийг тус тус зарцуулжээ

3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 151 мэдээллээс хугацаандаа оруулсан 136 мэдээлэл, хугацаа болоогүй 2 мэдээлэл, хугацаа хоцроосон 13 мэдээлэл, төсвийн хэтрэлт, хэмнэлтийн тайлбар, таван сая төгрөгөөс дээш дүнтэй 36 удаагийн 1163755.5 мянган төгрөгийн орлого, зарлагын гүйлгээ, 8 тушаал шийдвэр мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулаагүй байна.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж өгөөгүй байна.

3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 4391.9 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 200.0 мянган төгрөгийн зөрчилд 1 акт тогтоож, 1346.7 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлж, 2845.2 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 4 зөвлөмж өглөө.

Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаа илрээгүй, залруулга хийгээгүй болно.

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрснээс 200.0 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 1346.7 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлжээ. Үүнд:

1. Жолоочийн тооцооны хуудсыг түүвэрлэн тулгалт хийхэд анхан шатны баримтын хөтлөлт дутуу нь Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалын НХМаягт ТМ-4 маягт хөтлөх зааврыг бүрэн хэрэгжүүлээгүй, үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөх

2. Бичиг хэргийн материалын зардлаас 200.0 мянган төгрөгийг шууд зардлаар бүртгэж, тайлагнасан нь НББ-ийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5-д "Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно. Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна", 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэн заалтыг зөрчсөн, үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоох

3. Тамгын газрын даргын 2020 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн А/10 тоот тушаалаар тооллогын комиссыг 4 хүний бүрэлдэхүүнтэй томилсон боловч тооллогын комисс бараа материалын тооллогыг тогтоосон хугацаанд зааврын дагуу үнэн зөв, чанартай явуулж тооллогын явц үр дүнг комиссын хурлаар хэлэлцэж, тооллогын бүртгэлийг 2 хувь үйлдэж байгууллагын удирдлагад танилцуулан батлуулж, санхүүгийн албанд хүргүүлэх үүрэгтэй ч баримтын бүрдэл дутуу нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 4 дэх "комиссын хурлаар тооллогын үр дүнг хэлэлцэж, тооллогын бүртгэлийг баталгаажуулж, холбогдох акт, материалын хамт ерөнхий нягтлан бодогчид тусгай жагсаалтаар шилжүүлэн өгөх" гэсэн заалттай нийцэхгүй, тохиолдсон байх, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөх

Аудитын зөвлөмж

Аудитаар илэрсэн 2845.2 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 4 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийг биелэлт болон дотоод хяналт шалгалтын талаар авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1.Зардлын данстай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт: Цалингийн урьдчилгаа олгохдоо цалингийн урьдчилгаа дансаар дамжуулалгүй 2515.0 мянган төгрөгийн шууд зардлаар бичилт хийсэн нь НБББББ-ийн 5.10-д заасны дагуу бүртгэж тайлагнаагүй байна.

1.2. Эрсдэл: Санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх

1.3. Өгсөн зөвлөмж: Алдаатай бүртгэл хөтлөлтийг таслан зогсоож, НБББББ-ийн 5.10-д заасны дагуу бүртгэж тайлагнах

1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:Хүлээн зөвшөөрсөн

Сэлэнгэ сумын ЗДТГ-ын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2.Зардлын данстай холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт: Урсгал засварын зардлаас бичиг хэргийн материал бэлтгэсэн нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2-т "батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах", Сангийн сайдын 2014 оны 55 дугаар тушаалыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.

2.2. Эрсдэл: Үргүй зардал гарах, дотоод хяналт сулрах

2.3. Өгсөн зөвлөмж: Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2-т "батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах", Сангийн сайдын 2014 оны 55 дугаар тушаалыг бүрэн хэрэгжүүлж ажиллах

2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Хүлээн зөвшөөрсөн

3.Шилэн данстай холбоотой асуудал

3.1. Илрүүлэлт: Төсвийн хэтрэлт, хэмнэлтийн тайлбар, хугацаа хоцроосон 13 мэдээлэл, таван сая төгрөгөөс дээш дүнтэй 36 удаагийн 1163755.5 мянган төгрөгийн орлого, зарлагын гүйлгээ, 8 тушаал шийдвэр мэдээлээгүй нь Шилэн дансны тухай хуулийн 6.1.6, 6.4.5, Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журмын 2.2.1.6, 2.2.2.3 дахь заалтыг зөрчсөн, санхүүгийн тайлангийн үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

3.2. Эрсдэл: Хууль, журам зөрчигдөх, хариуцлага хүлээх

3.3. Өгсөн зөвлөмж: Шилэн дансны тухай хуулийн 6.1.6, 6.4.5, Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журмын 2.2.1.6, 2.2.2.3 дахь заалтыг бүрэн хэрэгжүүлж ажиллах

3.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Хүлээн зөвшөөрсөн

4. Худалдан авалттай холбоотой асуудал

4.1. Илрүүлэлт: НӨАТ тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3 дахь "Албан татвар суутган төлөгч хоорондын бараа борлуулсан, ажил гүйцэтгэсэн, үйлчилгээ үзүүлсэн тухай бүрд төлбөрийн баримт олгох бөгөөд уг баримтуудыг дангаар, эсхүл хамтатган нэмэгдсэн ертгийн албан татварын падаан үйлдэнэ", 17 дугаар зүйлийн 17.3.2 дахь "бараа, ажил, үйлчилгээг борлуулсан тухай бүр төлбөрийн баримтыг татвар төлөгчид олгоно", 17.5 дахь "Албан татвар суутган төлөгч төлбөрийн баримт олгохоос татгалзах, хуурамч буюу хийгдсэн төлбөр тооцооноос өөр дүнтэй төлбөрийн баримт олгохыг хориглоно" гэж заасныг бүрэн хэрэгжүүлээгүйгээс 871.8 мянган төгрөгийн төлбөрийн баримтгүй худалдан авалт хийсэн байна.

4.2. Эрсдэл: Хууль, журам мөрдөгдөхгүй байх

4.3. Өгсөн зөвлөмж: Хуулийн хэрэгжилтийг бүрэн хангах

4.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Төсвийн захирагч хүлээн зөвшөөрсөн

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2021 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАН ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

Д.АНХБАЯР

Ж.ЭНХЦООДОЛ

ТАЙЛАН БИЧСЭН:

АУДИТОР

А.СУВДАА